



МОНГОЛ УЛС  
ДУНГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2014 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/322

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Замын сангийн хөрөнгөөр хийгдэх "Хүүхдийн паркийн авто замын гарцаас МТ-ийн шатахуун түгээх станц хүртэлх явган хүний замын ажил"-ын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

М.Цогзолмаа -ТЗУХ-ийн дарга

Гишүүд:

Д.Мөнхцоож -Сайнцагаан сум ХТГ дарга

Т.Төрбат -Иргэний төлөөлөл

Д.Нэргүй -ГХБХБГ-ын барилгын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Т.Асралт -ОНӨГазар худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /М.Цогзолмаа/-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Т.Асралт /-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200881